



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 365

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн, 14,699,075.00 (арван дөрвөн сая зургаан зуун ерэн есөн мянга далан тав) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Цэндээ, Увс аймгийн Мал эмнэлгийн газрын Д.Ганхуяг дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай;

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Тогтоолын биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001839

17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ... ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УВС АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦАА
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Балансад бүртгэлтэй байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ /хуримдлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа (жилээр)	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)	Хүлээн авах байгууллага
1	Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар	Хүйтэн хэлхээ	2012-10-01	85	иж бүрдэл	11,715,975.00	5	50,000.00	4,250,000.00	Увс аймгийн Мал эмнэлгийн газар
2	Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар	Хөргөлтийн гадна төхөөрөмж	2012-10-01	1	иж бүрдэл	2,983,100.00	5	1,000,000.00	1,000,000.00	Увс аймгийн Мал эмнэлгийн газар
Нийт дүн				86		14,699,075.00 (арван дөрвөн сая зургаан зуун ерэн есөн мянга далан тав)		1,050,000.00	5,250,000.00 (таван сая хоёр зуун тавин мянга)	